

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, байгууллагуудын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх тухай

2018.03.26

№ 02

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а” дахь заалт, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 155 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн хэмжээнд 2018 оныг “Эрүүл мэндийг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан эрүүл мэндийг дэмжигч жилийн ажлын төлөвлөгөө, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, бэхжүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагаа, байгууллага, хамт олон, иргэдийн үүрэг хариуцлага, оролцоо идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга эрхлэгч нарт ДААЛГАХ нь:

**1. Сумдын Засаг даргын Тамгын газарт:**

1.1. Эрүүл мэндийг дэмжих жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг сум, баг, байгууллага бүр боловсруулан үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах.

1.2. Эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтний үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах, эрүүл мэндийн төлөөх түншлэл, салбар байгууллагуудын хамтын ажиллагаа, олон нийт, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

1.3. Иргэдийн дунд эрүүл зан үйл төлөвшүүлэх, сургалт мэдээлэл хийх ажлыг дэмжиж, иргэдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ төлөвлөж, үр дүнг тооцож ажиллах.

**2. Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд:**

2.1. Эхийн эндэгдлийн тохиолдлыг гаргахгүй байх, нялхасын эндэгдлийг бууруулах талаар онцгой анхаарч хэнийг ч орхихгүй байх зарчимд тулгуурлан нийгмийн эмзэг бүлэг зорилтот өрхөд илүүтэй анхаарч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэн төвтэй, тэдний хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэн хүргэж ажиллах.

2.2. Эмнэлгийн ажилчдын эрүүл мэндийн дэмжих, хамгаалах чиглэлээр анхаарах, эмч эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг тасралтгүй хөгжүүлэн, ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах.

2.3.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх сургалтын модуль хөтөлбөрийг боловсруулж, иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэвлэл 2.

мэдээллийн хэрэгсэл, эрүүл мэндийн байгууллагуудаар дамжуулан үр дүнтэй зохион байгуулж ажиллах.

### **3. Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвд:**

3.1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдэд хүлээгдэл, чирэгдэлгүй хүргэх, гэрийн эргэлт, хүүхдийн хяналт, жирэмсний хяналтын чанарыг сайжруулан ажиллах.

3.2.Орчин цагийн анагаах ухааны сүүлийн ололт, уламжлалт анагаах ухааны арвин баялаг аргыг зүй зохистой хослуулан хөгжүүлж тусламж үйлчилгээний багцаа нэмэгдүүлэх, хүн амыг өвчнөөс сэргийлэх, тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх.

### **4.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж:**

4.1.Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, ажлын байрны онцлог нөхцөлтэй уялдуулан идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрүүлжүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх.

4.2.Байгууллага бүр үйлчлүүлэгч, ажилчдын эрүүл мэндэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, ажил мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлж хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах.

### **5. Сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллагад:**

5.1.Цэцэрлэг, сургуулийн хүүхдийг амны хөндийн эрүүл мэнд, гар угаах, улирлын чанартай халдварт өвчнөөс сэргийлэх, дулаан хувцаслах зэрэг зөв дадал хэвшил төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагч, сурагчдын дунд сар бүр тогтмол зохион байгуулах.

5.2.Цэцэрлэг, сургуулийн дотуур байр, сургуулийн үдийн цай, хоол хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хяналт тавих, сургуулийн орчинд хориглосон хүнсний бүтээгдэхүүн худалдахыг хориглох.

### **6. Нийт иргэдэд уриалах нь:**

6.1.Иргэн бүр эрүүл мэндийн боловсролоо нэмэгдүүлэх, эрүүл зан төлөвшүүлэх, мэдээлэл сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд идэвхтэй хамтран оролцдог нийгмийн идэвхтэй гишүүн байх.

6.2.Хүүхдийг бага наснаас эхлэн гар угаах, шүд угаах, замын хөдөлгөөн оролцох, хоол хүнсээ зөв сонгон хэрэглэх, эрүүл зөв дадал хэвшилд төлөвшүүлэх, хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлж, хүүхдэд тавих анхаарал халамж, хариуцлагаа нэмэгдүүлэх.

6.3.Иргэн бүр гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр мэдлэгээ дээшлүүлж, гэр бүлээ зөв төлөвлөх, жирэмснээс хамгаалах арга хэрэгслийг сонгон хэрэглэх, эрүүл үедээ жирэмсэлж,

### 3.

жирэмсний хяналтад эрт орох, жирэмсэн үедээ эрүүл байж, эрүүл хүүхэд төрүүлэх дадал хэвшилд суралцах.

6.4.Хоол хүнс, ундны усыг хадгалахдаа эрүүл ахуйн стандарт, шаардлагад нийцсэн савыг сонгон хэрэглэж хэвших.

6.5.Хөрс орчны эрүүл ахуй, аюулгүй байдалд онцгой анхаарч, гэр хорооллын айлууд бие засах газар, бохир усны цооногтоо халдваргүйтгэл, шавьжгүйтгэлийн арга хэмжээг тогтмол хийж хэвших.

6.6.Элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ, хөх умайн хүзүүний хавдар, цусны даралт ихсэлт, чихрийн шижин, сүрьеэ зэрэг өвчний эрт илрүүлэгт бүрэн хамрагдах.

6.7.Эмийг зөв зохистой хэрэглэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, хорт зуршлаас татгалзах, зөв зохистой хооллолтыг хэвшүүлэх зэргээр сэргийлж болох өвчлөл, эндэгдлээс өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах.

7. Энэхүү албан даалгаврыг орон нутаг, байгууллагын түвшинд чанартай үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтийг 2018 оны 11 сарын 20-ны дотор Эрүүл мэндийн газарт тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга, нийт байгууллага, аж ахуйн нэгжид даалгасугай.

8. Албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Ү.Энхцацрал/, албан даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулах, үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн 2018 ны 11 сарын 30-ны дотор Засаг даргад тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Өнөржаргал/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.НАРАНБААТАР

